

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2013 оны 7 дугаар сарын 05-ны өдөр баталсан Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хууль зүйн туслалцааны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.11 дэх заалтын “ажиллагаа болон төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх ажлыг” гэснийг “ажиллагааг” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Хууль зүйн туслалцааны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ЦЭРГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.7 дахь хэсгийн “иргэнийг” гэснийг “иргэн, түүнчлэн улсын өмгөөлөгчөөр гурван жил тасралтгүй ажилласан Хууль зүйн туслалцааны төвийн хуульчийг” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хууль зүйн туслалцааны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.1.15 дахь заалт нэмсүгэй:

“15.1.15.төрөөс хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэхэд оруулсан санхүүгийн дэмжлэг, хандив, тусламж, хөрөнгө.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хууль зүйн туслалцааны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.2.4 дэх заалт нэмсүгэй:

“25.2.4.төрөөс хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хууль зүйн туслалцааны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 15.8 дугаар зүйлийн гарчгийн “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль” гэснийг “Хууль” гэж, тус зүйлийн 1 дэх хэсгийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа яллагдагч” гэснийг “Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах хүн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хууль зүйн туслалцааны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг